



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 521

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Булган аймаг дахь Хөдөө аж ахуйн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон нийт 21 нэрийн 31,855,444.00 (гучин нэг сая найман зуун тавин таван мянга дөрвөн зуун дөчин дөрвөн төгрөг) төгрөгийн балансын үнэ, бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Булган аймаг дахь Хөдөө аж ахуйн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн захирал Н.Пүрэвсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001406

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 11 дүгээр сарын .../...-ны өдрийн
...521... дугаар тогтоолын хавсралт

Булган аймаг дахь Хөдөө аж ахуйн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй актлаж данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Тооно	2015.12.01	2	230,000.00	460,000.00
2	Хаалга	2015.12.01	2	230,000.00	460,000.00
3	Багана	2015.12.01	2	160,000.00	320,000.00
4	Унь /81ш/	2015.12.01	2	420,000.00	840,000.00
5	Хана /5ш/	2015.12.01	2	400,000.00	800,000.00
6	Шал	2015.12.01	2	350,000.00	700,000.00
7	Эсгийн туурга /8ш/	2015.12.01	2	320,000.00	640,000.00
8	Эсгийн дээвэр	2015.12.01	2	320,000.00	640,000.00
9	Брезент	2015.12.01	2	190,000.00	380,000.00
10	Цагаан бүрээс	2015.12.01	5	50,000.00	250,000.00
11	Дотуур цаваг	2015.12.01	5	30,000.00	150,000.00
12	Хөшиг ком	2015.12.01	5	53,000.00	265,000.00
13	Өрх	2015.12.01	5	25,000.00	125,000.00
14	Хаяавч	2015.12.01	5	30,000.00	150,000.00
15	Гэрийн хошлин ком	2015.12.01	5	22,000.00	110,000.00
16	Гэрийн бүслүүр 15м/кв	2015.12.01	5	150,000.00	750,000.00
17	Гал тогооны майхны эсгий шалавч	2015.12.01	1	160,000.00	160,000.00
18	Өлзий зуух	2015.12.01	2	372,727.00	745,454.00
19	Мэдээлэл хангамжийн праграмм	2016.10.10	1	14,500,000.00	14,500,000.00
20	Давхар төмөр ор	2011.01.01	31	300,000.00	9,300,000.00
21	Будаа агшаагч	2011.06.01	1	109,990.00	109,990.00
	Нийт дүн		89		31,855,444.00 (гучин нэг сая найман зуун тавин таван мянга дөрвөн зуун дөчин дөрвөн төгрөг)